



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/39

Арвайхээр сум

Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний
журам, үнийн жишиг батлах тухай

“Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, 24.5, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, “Төсвийн тухай хуулийн” 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн” 7 дугаар зүйлийн 7.1.5, 11 дүгээр зүйлийн 11.1, 13 дугаар зүйлийн 13.1.9 “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн” 2022 оны 01 дүгээр тогтоол, “Сангийн сайд”, “Эрүүл мэндийн сайдын” хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар “Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс иргэн, байгууллагад үзүүлэх “Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Сангийн сайд”, “Эрүүл мэндийн сайдын” хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаалаар баталсан жагсаалт, үнийн жишиг хэмжээний дагуу өөрийн байгууллагын үйлчилгээний хүрээнд тохируулан “Жагсаалт, төлбөрийн жишиг хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2023 оны 04 сарын 18 өдрөөс эхлэн мөрдтүгэй.

2.Журмыг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), тасгийн эрхлэгч, ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тусламж үйлчилгээний санхүүжилтийн орлогыг төсөвт төвлөрүүлж биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх), Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа), Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр), Эдийн засагч (Б.Цэрэндолгор) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн захирлын “Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журам батлах тухай” 2022 оны 06 дугаар сарын 06 өдрийн дугаар А/ 23 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН